


НҮБ-ын Дэлхийн усны хөгжлийн 2023 оны тайлан

Усны төлөөх түншлэл, хамтын ажиллагаа

Хураангуй



1977 оноос хойш зохион байгуулагдаж буй НҮБ-ын усны асуудлаарх анхны томоохон бага хурал 2023 онд болно. НҮБ-ын 2023 оны усны бага хурал нь ус хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой зорилтуудын хэрэгжилтийн үйл явцад анхаарлаа хандуулах бөгөөд энэхүү арга хэмжээ нь "Тогтвортой хөгжлийн төлөөх ус – Олон улсын арван жилийн үйл ажиллагаа 2018-2028" сэдэвт 10 жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээний ажилтай давхцаж байгаагаараа онцлогтой юм.

НҮБ-ын системийн усны асуудлаарх итгэмжлэгдсэн тайлан болох НҮБ-ын Дэлхийн усны хөгжлийн 2023 оны тайланд тогтвортой хөгжлийн бүхий л хэмжигдэхүүнийг хамарсан түншлэл, хамтын ажиллагааг сайжруулах нь баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах тухай Тогтвортой хөгжлийн 6-р зорилгод хүрэхийн тулд авч буй арга хэмжээнүүдийн ахиц дэвшлийг хурдасгах, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийг хангахад чухал ач холбогдолтой болохыг тайлбарлаж, НҮБ-ын Усны бага хурлаар хэлэлцэх асуудлуудыг тодорхойлсон.

Дэлхийн ус: Эрэлт хэрэгцээ, хүртээмж, чанар

Сүүлийн 40 жилийн хугацаанд усны хэрэглээ дэлхийн хэмжээнд жилд 1 орчим хувиар нэмэгдэж байгаа бөгөөд хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн хөгжил, хэрэглээний хэв маягийн өөрчлөлтөөс шалтгаалан 2050 он хүртэл мөн адил энэ хурдаараа өсөх төлөвтэй байна. Энэхүү өсөлтийн дийлэнх нь дунд болон бага орлоготой орнуудад, ялангуяа хөгжиж буй эдийн засагтай орнуудад төвлөрч байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас орон нутгийн усны гачигдлыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлс болон цэнгэг усны бохирдол нэмэгдэж байгаатай холбоотойгоор усны хомсдол орон нутгийн чанартай болж байна. Төв Африк, Зүүн Ази, Өмнөд Америкийн зарим хэсгүүд зэрэг одоогийн байдлаар ус элбэг байгаа бүс нутагт улирлын чанартай усны хомсдол нэмэгдэж, Ойрхи Дорнод, Африкийн Сахел зэрэг усны хомсдолд аль хэдийн орчихсон бүс нутгуудад усны хомсдол илүү ихээр нэмэгдэх болно. Дунджаар дэлхийн хүн амын 10% нь усны их хэмжээний гачигдалтай эсвэл устай холбоотой хурцадмал асуудлуудтай орнуудад амьдарч байна.

Бага, дунд, өндөр орлоготой орнуудын аль алинд нь усны чанартай холбоотой эрсдэлийн шинж тэмдгүүд байдаг. Орлого багатай орнуудын байгалийн усны чанар муу байгаа нь ихэвчлэн бохир ус цэвэршүүлэлтийн түвшин бага байдагтай холбоотой байдаг бол өндөр орлоготой орнуудад хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас үүдэлтэй бохир ус нь илүү ноцтой асуудал болдог. Гэсэн хэдий ч усны чанарын талаарх мэдээлэл ховор хэвээр байгаа нь гол төлөв улс орнуудын мониторинг хийх, тайлагнах чадавх сул байгаагаас шалтгаалж байна. Энэ нь ялангуяа Ази, Африкийн буурай хөгжилтэй орнуудад илүү түгээмэл байгаа юм.

ТХ-ийн 6-р зорилгын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшил

Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт хугацааны эхний хагаст ТХ-ийн 6-р зорилгод хүрэх ахиц дэвшилтэй холбоотой баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаарх мэдээлэл нэлээд элбэг байгаа боловч усны гачигдлыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлс, ус ашиглалтын үр ашиг, хил дамнасан хамтын ажиллагаа, усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ) зэрэгт ахиц дэвшил гарсан талаарх мэдээлэл хомс, зөвхөн урьдчилсан болон боловсронгуй бус үзүүлэлтүүд байгаа бөгөөд зорилтот 11 үзүүлэлтээс 5 зорилтын хэрэгжилтийн талаарх тоон мэдээлэл нь байхгүй байна.

Одоогийн хурдаар ТХ-ийн 6-р зорилгын бүх зорилтуудыг хугацаанд нь хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд тус зорилгын хэрэгжилтийг хугацаанд нь хангахын тулд зарим бүс нутагт одоогийнхоос 4 дахин илүү хурдтайгаар холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

2020 оны хамгийн сүүлийн үеийн тоо баримтаас харахад дэлхийн хүн амын 26% (2 тэрбум хүн) нь баталгаат ундны усны үйлчилгээгээр (**Зорилт 6.1**), 46% (3.6 тэрбум) орчим нь аюулгүй удирдлагатай ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй хэвээр байна (**Зорилт 6.2**).

Дэлхийн усны нөөцийн 60 орчим хувь нь байгалийн усны чанар сайтай хэмээх ангилалд багтсан (**Зорилт 6.3**) боловч дэлхийн хамгийн ядуу 20 орны төлөөллийг дэлхийг хамарсан энэхүү тооцоонд тусгаагүй байна.

2015-2018 онд ус ашиглалтын үр ашиг (**Зорилт 6.4**) дэлхийн хэмжээнд 9%-иар (17.3 ам.доллар/м3 -ээс 18.9 ам.доллар/м3 болж) өссөн байна. Аж үйлдвэрийн салбарт хамгийн их ахиц дэвшил гарсан (15%-иар өссөн) бол ус хангамж, ариун цэврийн байгууламж, хөдөө аж ахуйн салбарын ус ашиглалтын үр ашиг 8%-иар өссөн байна.

Ихэнх орнууд тодорхой хэмжээний ахиц дэвшил гарч байгаа талаар тайландаа дурдаж байгаа хэдий ч УННМ-ийн хэрэгжилтийг хугацаанд нь хангаж, зохих ахиц дэвшлийн түвшин (**Зорилтот 6.5**)-д хүрэхийн тулд одоогийнхоосоо хоёр дахин илүү хурдтайгаар холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Устай холбоотой экосистемийн хамрах хүрээ цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж байгааг хянахад шаардлагатай өгөгдөл (**Зорилт 6.6**) нь сүүлийн жилүүдийн чиг хандлагуудыг тус тусад нь харуулахад хангалттай бус байна. Гэсэн хэдий ч аж үйлдвэрийн хувьсгалын өмнөх үе (1700)-ээс хойш байгалийн ус намгархаг газрын хэмжээ 80%-аар буурсныг бэлэн байгаа тоо баримтууд харуулж байна.

"Ус"-нд зориулж олгосон Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) 2002 онд 2.7 тэрбум америк доллар байсан бол 2020 онд 8.7 тэрбум америк доллар болж өссөн байна. Гэвч ус хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой үйл ажиллагаа, хөтөлбөрүүд (**Зорилт 6.а**) -ээр дамжуулан хөгжиж буй орнуудад олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, чадавхыг бэхжүүлэхэд зориулан өгсөн дэмжлэгийн талаар энэхүү тайланг гаргах хүртэлх хугацаанд хараахан мэдээлээгүй байна.

Хэрэглэгчид/олон нийтийн оролцоог хангах хууль тогтоомж эсвэл бодлогод тодорхой журмыг тусгасан улс орнуудын тоо (**Зорилт 6.б**) 2014-2019 оны хооронд өссөн боловч ерөнхийдөө цөөн хэвээр байна. Бусад дэд салбаруудтай харьцуулахад хот, хөдөөгийн аль алинд нь ундны устай холбоотой хууль/дүрэм журам болон оролцооны түвшин маш бага байна.

Түншлэл, хамтын ажиллагааны олон талт байдал

ТХ-ийн 6-р зорилгын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшил одоогоор хангалтгүй байгаа нь түншлэл, хамтын ажиллагаагаар дамжуулан зохих боломжуудыг судлах шаардлагатай байгааг харуулж байна. Хамтын ажиллагаа нь усны засаглал, шийдвэр гаргах чадавхыг сайжруулахын зэрэгцээ шинэлэг шийдлүүдийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлдэг. Түншлэл нь хамтын ажиллагаа, оролцоо, яриа хэлэлцээг дэмжиж, өмнө нь дуу хоолойгоо хүргэх боломжгүй байсан хүмүүст дуу хоолойгоо хүргэх боломжийг бий

Хамтын ажиллагаа нь усны засаглал, шийдвэр гаргах чадавхыг сайжруулахын зэрэгцээ шинэлэг шийдлүүдийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлдэг.

болгох замаар хэнийг ч орхигдуулахгүй байх, цаашлаад баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийг хангахад чухал ач холбогдолтой юм. Оролцогч талууд нь өөр өөрийн гэсэн мэдлэг ойлголт, сонирхол, байр суурь, зорилттой байдаг тул тэдгээрийн хооронд тэргүүлэх чиглэл, стратегийн талаар санал зөрөлдөх явдал түгээмэл байдаг. Түншлэл, хамтын ажиллагаа нь бүхий л түвшинд эерэг үр дүнг бий болгодог боловч цөөн тохиолдолд нийгмийн зарим бүлгийг орхигдуулж, нөөцийн хуваарилалтыг гажуудуулан хагарал бутралыг бий болгох магадлалтай байдаг. Энэхүү тайланд хамтын ажиллагаагаар дамжуулан хүрэхийг зорьж буй устай холбоотой үр дүнд үндэслэн бид оролцогч талуудыг дараах 3 сэдэвчилсэн ангилалд хуваасан болно. Эхний ангилалд орон нутгийн иргэдийг ус, ариун цэврийн байгууламжаар хангах эсвэл хамтын усалгааны системийг удирдах гэх мэт **нийтлэг зорилготой** түншүүд багтана. Хоёр дахь ангилалд ус хангамжийг хуваарилахтай холбоотой хотын захиргаад болон тариаланчдын хамтын ажиллагаа, байгаль орчны үйлчилгээний системийн төлбөр зэрэг **устай холбоотой** (өрсөлдөөнтэй байж болзошгүй) **төрөл бүрийн** зорилготой талууд хамарна. Харин гурав дахь ангилалд устай шууд холбоогүй боловч үйл ажиллагаанд нь ус чухал үүрэг гүйцэтгэдэг талууд хамарна. Эдгээр түншлэл нь хүний эрүүл мэнд эсвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг бууруулахтай холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэх зорилготой усны асуудлаарх хөндлөнгийн оролцоог дэмждэг.

Салбаруудын хэтийн төлөв

Хөдөө аж ахуй

Ус ашиглагчдын холбоо (УАХ) нь хамтын усалгааны системийг газар тариалан эрхлэгчдээр дамжуулан удирдан зохицуулдаг албан ёсны байгууллага юм. Тариаланчид нь адил хэм хэмжээтэй, орон нутгийн бусад холбогдох байгууллагууд (жишээлбэл, орон нутгийн зөвлөл эсвэл шашны бүлгүүд)-ын нийтлэг үнэт зүйлс болон нөөцтэй, орон нутгийн төрийн бус байгууллагууд (ТББ)-ын урт хугацааны оролцоотой, ардчилсан дотоод үйл явцтай (тухайлбал сонгогдсон дарга болон удирдах зөвлөлийн гишүүдтэй) жижиг хэмжээний ус ашиглагчдын холбоод хамгийн их амжилттай байдаг бол бусад нь хэрэгжилт муу, үүрэг хариуцлага нь тодорхой бус, эмэгтэйчүүдийн оролцоо бага, удирдлагын эрх мэдэл дутмаг зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан төдийлөн амжилтад хүрдэггүй. Мөн Засгийн Газар (тухайлбал Усалгааны газар, Усны асуудал хариуцсан яам)-аас гаргасан холбогдох үндэсний удирдамжуудыг ихэвчлэн хууль тогтоомж, дүрэм журмаар дамжуулан хэрэгжүүлэх нь УАХ-дын үр нөлөөг хязгаарлах нэг хүчин зүйл нь болдог байж болох юм.

Усыг хөдөө аж ахуйгаас хот суурин газар руу хуваарилах нь хөгжиж буй хотуудын цэвэр усны хэрэгцээг хангах нийтлэг стратеги болоод байна.

2050 он гэхэд хотын усны хэрэгцээ 80%-аар өсөх төлөвтэй байгаа тул усыг хөдөө аж ахуйгаас хот суурин газар руу хуваарилах нь хөгжиж буй хотуудын цэвэр усны хэрэгцээг хангах нийтлэг стратеги болоод байна. Өдрөөс өдөрт өсөн тэлж буй хотуудын хэрэгцээг хангах үүднээс хөдөө аж ахуйгаас усыг дахин хуваарилах ажил ерөнхийдөө амжилттай хийгдэж байгаа юм. Хөдөө аж ахуй/хөдөөгийн нөхцөл байдалд үзүүлэх нөлөөллийн хэтийн төлөвөөс харахад усалгаанд хэрэглэх усны хэмжээ багасаж байгаагаас шалтгаалан хүнсний аюулгүй байдал, тариаланчдын амьжиргааны орлогыг бууруулах зэрэг сөрөг үр дагаврууд бий болж байгаа нь ажиглагдаж байна. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсвэл шинэ дэд бүтцийг барьж байгуулах зэргээр нөхөн олговор олгох, үр ашгийг хуваах зохицуулалт хийх зэргээр эдгээр сөрөг үр дагаврыг арилгах боломжтой юм.

Ус, эрчим хүч, хүнс, экосистем (Water, energy, food, and ecosystem - WEFE) хоорондын харилцаа холбоо нь ус, эрчим хүч, хүнс, экосистем хоорондын харилцан үйлчлэл,

зөрчилдөх хүчин зүйлсийг харуулсан системчилсэн арга барилаар хангадаг. Ус, эрчим хүч, хүнс, экосистем хоорондын уялдаа холбоо нь бүх салбарыг нэгтгэж, хүмүүс болон хүрээлэн буй орчны тус тусын зорилго, ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн тогтвортой байдлын цогц алсын харааг бий болгодог.

Байгаль орчин

Усны сав газрыг хамгаалах буюу нөхөн сэргээх арга хэмжээ нь устай холбоотой хамгийн эртний түншлэлүүдийн нэг хэлбэр юм. Усны сав газрын үйлчилгээний системүүд нь системийнхээ тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон түүний нөлөөллийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Экосистемд суурилсан арга барилын үр дүнд бий болсон үр ашиг нь байгальд суурилсан шийдлүүдийн гол үндэслэл нь болж өгдөг. Ус хангамжийн байгууллагуудын гол сонирхол нь дэд бүтцийн эрсдэлийг бууруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зардлыг бууруулах явдал юм. Үерийн нөлөөллийг бууруулах зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнээс үүдэлтэй үр өгөөж нь хөдөө орон нутгийн иргэдийн сонирхлыг ихээхэн татдаг. Цаашлаад, биологийн олон янз байдлыг хамгаалах, ажлын байр бий болгох, чадавхыг бэхжүүлэх зэрэг олон ашиг тустай юм. Энэхүү ашиг тусын олон талт байдал, өргөн цар хүрээ нь илүү өргөн хүрээний оролцогч талууд болон боломжит түншүүдийн хүчтэй ашиг сонирхлыг бий болгодог.

Усны системийг санхүүжүүлдэг сангууд нь усны чанар, тоо хэмжээг сайжруулах, урт хугацааны үр өгөөжийг бий болгохын тулд голын эх хэсгийн амьдрах орчныг хамгаалах, газрын менежментэд хамтран хөрөнгө оруулах зорилгоор хот, аж ахуйн нэгж, нийтийн аж ахуйн байгууллагууд зэрэг ус хэрэглэгчдийг нэгтгэдэг түншлэлийг дэмждэг.

Байгаль орчны хяналтыг сайжруулахад орон нутгийн иргэдийг оролцуулсан түншлэлийг бэхжүүлэх явдал өсөн нэмэгдсээр байна. Энэ нь усны чанарын талаарх мэдээллийн дутмаг байдлыг арилгахад чухал ач холбогдолтой юм.

Хүн амын суурьшил

Хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон нийт, ус, ариун цэвэр, эрүүл ахуй (WASH), эрүүл мэнд, орон сууц, хөдөө аж ахуй, боловсрол, төлөвлөлт, дэд бүтцийг хариуцсан Засгийн Газрын холбогдох яам, газрууд зэрэг олон талт оролцогч талууд нь ус, ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой төрөл бүрийн асуудлуудыг зохицуулдаг. Хамтын ажиллагаа нь түншлэлийн хүрээг илүү өргөтгөх боломжийг бий болгож өгдөг.

Зорилтот бүлгийн үр шимийг хүртэгчдийн, ялангуяа хөдөө орон нутаг болон хоёрдогч хотуудын идэвхтэй оролцоо нь ус, ариун цэвэр, эрүүл ахуйн санаачлагууд зорилгодоо хүрэхэд чухал ач холбогдолтой юм. Төлөвлөлт, хэрэгжилтэд оролцогч талууд үр дүнтэй оролцох нь орлого багатай иргэдийн хэрэгцээ шаардлага болон нөөцөд илүү тохирсон үйлчилгээг бий болгож, холбогдох системийг олон нийт хүлээн зөвшөөрч, эзэмших байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Оролцогч талуудын оролцоо нь хариуцлагатай байдал, ил тод байдлыг ч мөн нэмэгдүүлдэг.

Усны операторуудын түншлэл (УОТ) нь амжилттай сайн ажиллаж байгаа байгууллагуудыг дэмжлэг, заавар зөвлөгөө шаардлагатай бусад байгууллагатай холбож өгдөг. Үүний үр дүнд сайжирсан хүчин чадал болон гүйцэтгэл нь холбогдох нийтийн аж ахуйн нэгжүүдийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн

Усны сав газрын үйлчилгээний системүүд нь системийнхээ тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон түүний нөлөөллийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Тухайлбал, ус хэрэглэгчдийн хороод нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар орон нутгийн усны асуудал хариуцсан эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих боломжтой.

хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг нь цаашид өргөтгөх, сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд тус дөхөм болдог. Цаашлаад, УОТ нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хүн амд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад ашиглаж болох чухал үнэ цэнтэй хэрэгсэл юм.

Шилжилт хөдөлгөөнийг албадан хэрэгжүүлэх нь ус хангамж, үйлчилгээгээр хангах үүрэгтэй орон нутгийн байгууллагууд (компаниуд, түншлэл)-д ихээхэн ачаалал өгдөг. Улс орнууд шилжилт хөдөлгөөнд хамрагдсан холбогдох хүмүүсийн эрхийг хангах үндсэн үүргийг хүлээдэг боловч шилжин ирж буй хүн ам болон хүлээн авагч талын аль алинд нь тулгарч буй цогц динамик асуудлуудыг НҮБ-ын агентлагууд, олон улсын байгууллагууд, ТББ-ууд болон иргэний нийгэм хамтран ажиллах замаар шийдвэрлэх шаардлагатай юм. Тухайлбал, ус хэрэглэгчдийн хороод нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар орон нутгийн усны асуудал хариуцсан эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих боломжтой.

Аж үйлдвэр

Хүссэн үр дүндээ зөвхөн дотоодын болон нэг талт үйл ажиллагааны хүрээнд хүрэх боломжгүй үед аж үйлдвэрийн хамтын ажиллагааг хөгжүүлдэг. Аж үйлдвэр нь ТХЗ-уудын хэрэгжилтийг их хэмжээгээр хурдасгах хариуцлагатай үйл ажиллагаа болон зах зээлд суурилсан шийдлүүдийн ахиц дэвшлийг нэмэгдүүлэх чадвартай боловч засаглалын хангалтгүй байдал, нөөцийн үр ашиггүй хуваарилалт, соёлын ялгаанаас үүдэлтэй саад бэрхшээлүүд, үл итгэлцэл зэрэг хүчин зүйлс нь энэхүү чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд эдгээр саад бэрхшээлийг даван туулахад эвсэл, хамтын үйл ажиллагаа зэрэг хэлбэрийн түншлэлүүд чухал юм.

Компаниуд нь хамтарсан үйл ажиллагаагаа үр дүнтэй болгохын тулд уламжлалт бус түншүүдтэй шинэлэг харилцаа холбоо тогтоож хамтран ажиллах шаардлагатай болдог. Мөн талууд хамтарсан зорилгынхоо төлөө тууштай байх, цаашлаад компанийн болон олон нийтийн ашиг сонирхлын хооронд тодорхой хэмжээний зөрчил үүсэж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хамтын ажиллагаа нь компаниудаас олон нийтийн хэрэгцээ шаардлага, үнэт зүйлсийн талаар илүү их ойлголттой болох, Засгийн Газрын оролцогч талууд болон ТББ-уудтай харилцаа холбоо тогтоох чадвараа сайжруулах зэрэг шинэ ур чадвар, мэдлэгийг хөгжүүлэхийг шаарддаг.

Зөвхөн арилжааны утгаар бус усны тогтвортой байдлыг хангаж, хүн бүрт ашигтай үр дүнд хүрэхийн тулд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) болон усны менежментийг ийм зохицуулалтад хамруулснаас үүдэлтэй гарч буй ач холбогдол нь сүүлийн жилүүдэд ихээр өсөн нэмэгдэж байна.

Эрүүл мэнд

Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй болон эрүүл мэндийн салбар хоорондын харилцан хамаарлаас гадна эдгээр салбарыг өөр өөр яамд, орон нутгийн засаг захиргаа, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд удирддагаас шалтгаалан зохицуулалт болон засаглалын ялгаанууд гарч байна. Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн сүлжээний үйл ажиллагаанаас үүдэн гарч буй эрүүл мэндийн үр дүнг илүү оновчтой болгож, хурдасгахад шинжлэх ухаан, стратеги, үйл ажиллагааны түвшинд уялдсан түншлэл зайлшгүй шаардлагатай.

Эрүүл мэндийн байгууллагууд дахь ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа нь аюулгүй, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй

шаардлагатай. Эрүүл мэндийн салбар нь эмнэлэг, эрүүл мэндийн төвийн амбулатори, эмнэлгүүдэд ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй боловч ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээг хэрхэн хөгжүүлж, тогтмол үйл ажиллагааг нь хангах мэдлэг дутмаг байдлаас эсвэл эмчилгээний ажлынхаа ачааллаас шалтгаалан энэхүү үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрдөггүй, саяхныг хүртэл орхигдуулдаг байсан. Гэвч КОВИД-19 цах тахалтай холбоотой хүчин чармайлтууд нь ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний бодлого, зохицуулалт, хөрөнгө оруулалтыг бэхжүүлэх гол хөшүүрэг нь болоод байна.

Эмийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл болон гэр ахуйн химийн бодисууд, хувийн арчилгааны бүтээгдэхүүнүүд, пестицид, үйлдвэрлэсэн наноматериал зэрэг "шинээр гарч ирж буй усны бохирдуулагч"-д нь эрүүл мэндэд шинэ эрсдэлүүдийг үүсгэж байна. Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ нь өмнө нь төдийлөн ач холбогдол өгдөггүй байсан халуун орны өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ тус өвчнийг дахин дэгдэхээс сэргийлдэг. Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй үйлчилгээ нь ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээгээр дамжуулан нянгийн тархалтаас урьдчилан сэргийлэх замаар нянгийн эсрэг эмийн хэрэглээг хязгаарлаж, улмаар нянгийн халдварыг эсэргүүцэх чадвартай холбоотой хямралыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг. Энэ асуудлаар ахиц дэвшилд хүрэхийн тулд бодлого боловсруулагчид, инженерүүд, эрдэмтэд, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, малын эмч нар, тариаланчид, санхүүжүүлэгчид, төрийн бус байгууллагууд, хувь хүмүүс, корпорациуд зэрэг өргөн хүрээний оролцогч талууд хамтран ажиллах шаардлагатай юм.

Оношилгооны шинжилгээнд бохир уснаас үүдэлтэй өвчний тандалтыг нэмэлт болгон оруулж болно. Халдварт саа өвчнийг устгах дэлхийн хөтөлбөр нь бохир усыг илүү өргөн хүрээтэй тандалт, хяналтын хэрэгслийн нэг болгон ашигладаг эрүүл мэндийн салбарын (бохир усны лабораториудтай хийдэг) түншлэлийн нэг тогтсон жишээ юм.

Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгал, усны асуудлыг зохицуулах нь хоёр салбарыг хамарсан ажил юм. Нэг талаас, уур амьсгалын бодлого боловсруулагчид нь усны нийгэмлэгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хэрэгцээ шаардлага болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад усны нөөцийн менежмент, хангамж, ариун цэврийн байгууламжийн гүйцэтгэх үүргийг илүү сайн ойлгох хэрэгтэй. Нөгөө талаас, усны бодлого боловсруулагчид нь уур амьсгалд тулгуурласан үйл явцын талаар илүү сайн ойлгож, уур амьсгалын устай холбоотой эрсдэлийг үндэсний усны бодлого, стратеги, төлөвлөгөөнд тусгах зорилгоор уур амьсгалын асуудлаар оролцогч талуудтай идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай юм.

Ус, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагаагаар дамжуулан авах арга хэмжээг идэвхжүүлэх нь цэнгэг усны экосистем болон уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртдөг, эмзэг бүлгийн хүмүүст нэмэлт үр өгөөжийг бий болгох, цаашлаад гамшгийн эрсдэлийг бууруулах, зардлыг хэмнэх, ажлын байр бий болгох, эдийн засгийн боломжуудыг бий болгох зэрэг олон ач холбогдолтой юм. Ус, уур амьсгалын өөрчлөлтийн олон салбарыг хамардаг байдал болон газар нутаг, эрчим хүч зэрэг байгалийн бусад чухал нөөцтэй холбоотой харилцан хамаарал нь түншлэл, хамтын ажиллагааны цаашдын боломжуудыг бүрдүүлдэг.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрийн хамтын амлалтад улс орнуудын 80 гаруй хувь нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажлын тэргүүлэх чиглэл нь цэнгэг усны нөөц хэмээн дурдсан. Гэсэн хэдий ч бохир ус цэвэршүүлэх

системээс био хийг гарган авах, газрын гүний дулааныг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх зэрэг асуудлыг усны менежментээр дамжуулан зохицуулах замаар нөлөөллийг бууруулах боломжууд нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх мэргэжилтнүүдийн анхаарлыг татаж, усны оролцогч талуудтай цаашид хамтран ажиллах үүд хаалгыг нээж өгдөг байх хэрэгтэй юм.

Бүс нутгийн хэтийн төлөв

Сахарын цөлийн өмнөд хэсэгт орших Африкийн бүс нутаг

Хамтын ажиллагаа нь бүс нутгийн Хил дамнасан сав газрууд болон уст давхаргын усны аюулгүй байдлыг хангахад онцгой ач холбогдолтой.

Усны дэд бүтцийг хөгжүүлэх, газрын доорх усны нөөцийг ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах шинжлэх ухаан, технологид хөрөнгө оруулалт хийх нь Сахарын цөлийн өмнөд хэсэгт орших Африкийн газар нутгуудын усны аюулгүй байдлын тогтвортой байдлыг хангахад чухал хэрэгтэй юм. Гэсэн хэдий ч Африкийн усны салбарын оролцогч талуудад ерөнхийдөө хязгаарлагдмал байдаг өгөгдөл, мэдээллийн зохицуулалт, харилцаа холбоо, мэдээлэл солилцоо нь судлаачид, шийдвэр гаргагчид болон олон нийтийн бүлгүүдийн гишүүдийн хоорондын яриа хэлэлцээрийг сайжруулахад чиглэсэн зохих стратеги, платформ байхгүйн улмаас маш сул байна. Хамтын ажиллагаа нь бүс нутгийн хил дамнасан сав газрууд болон уст давхаргын усны аюулгүй байдлыг хангахад онцгой ач холбогдолтой.

Усны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон олон нийтээс сонгогдсон бүлгүүдийн хооронд ихэвчлэн байгуулагдсан төр-олон нийтийн түншлэл нь хувийн операторууд, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагууд болон олон нийт хоорондын харилцан ойлголцол, хамтын үүрэг хариуцлага, мэдлэг туршлагын солилцоогоор дамжуулан харилцан үр өгөөж хүртэх боломжийг агуулсан зохицуулалтыг бий болгох боломжийг бүрдүүлдэг.

Одоогийн байдлаар хүчин чармайлт, нөөцийг бүх түвшинд оновчтой болгох зохицуулалтыг шаарддаг олон үйл ажиллагаа байна. Дэд бүс, бүс нутаг, тив дамнасан хэд хэдэн түншлэлийг бэхжүүлэх боломж байна. Гишүүн орнууд, хөгжлийн түншүүд болон бусад оролцогч талууд одоо байгаа бүтцийг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулах нь шинэ бүтцийг бий болгохоос илүү чухал юм.

Европ ба Хойд Америк

Устай холбоотой түншлэл, хамтын ажиллагааны санаачилгууд нь Европ болон Хойд Америкт элбэг байдаг. *Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх тухай конвенц, Хил дамнасан ус болон олон улсад хамаарах нууруудыг хамгаалах, ашиглах тухай олон улсын конвенц* болон Европын холбооны холбогдох хэд хэдэн удирдамжид оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоо чухал шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байдаг. Эдгээр баримт бичгүүд нь бүс нутагт олон хэлбэрийн түншлэлийг хөгжүүлэхэд тус дөхөм болж, бүс нутгийн бус оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Холбогдох талуудын оролцоо нь идэвхтэй хэрэгжүүлсээр ирсэн зорилтуудын нэг боловч бүс нутгийн хэмжээнд усны менежмент, засаглал, хамтын ажиллагааны томоохон сорилтуудын нэг хэвээр байна.

Канад, Америкийн Нэгдсэн Улс хоорондын Олон улсын хамтарсан комисс (ОУХК) нь зөвхөн хил дамнасан хамтын ажиллагаагаар хязгаарлагдахгүй улс орнууд, салбар, засаг захиргааны түвшний болон оролцогч талуудын хоорондын усны хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ирсэн түүхтэй.

Латин Америк ба Карибын тэнгис

Энэ бүс нутгийн хамтын ажиллагааны төрөл бүрийн хэлбэрүүд нь усны салбар эсвэл хөдөө аж ахуй зэрэг уснаас хамааралтай салбаруудтай нягт холбоотой байна. Нийгмийн шударга ёс, жендэр, боловсрол, ажлын байр бий болгох, биологийн олон янз байдал зэрэг байгаль орчны бусад асуудлуудтай холбоотой усны салбарын бус талуудын оролцоо хязгаарлагдмал байгааг зарим нэг баримтууд харуулж байна.

Орон нутгийн түвшинд, ялангуяа хөдөө орон нутагт ундны ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээнд хяналт тавих зорилгоор устай холбоотой түншлэлүүд хамгийн нийтлэг байдаг. Мөн ус ашиглагчдын холбоо зэрэг хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн бүлгүүд өргөн тархсан. Эдгээр холбоодын нэг нийтлэг шинж чанар нь хот суурин газрын зохицуулагчдаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд төрөл бүрийн түвшинд үндэсний түвшний эрх баригчдын оролцоог хангасан байдаг. Тус бүс нутагт ихэвчлэн мэдээллийн хяналт, судалгаа, үйл ажиллагааны зохицуулалт, төлөвлөлт, санхүүжилт, бүтээн байгуулалт, удирдлага зэрэгт голлон анхаардаг олон жилийн түүхтэй сав газрын менежментийн байгууллага олон байдаг. Эдгээр байгууллага нь техникийн хүчин чадал, засаглалын бүтэц, санхүүжилт зэрэгтэй холбоотой ижил төстэй сорилтуудтай тулгардаг.

Усны менежментийг сайжруулах зорилгоор хамтран ажилладаг төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллага хоорондын асуудлыг зохицуулдаг нэмэлт зохицуулалтууд байдаг. Үүнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, олон нийтийн болон үндэсний сүлжээнүүд, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд оролцдог.

Ази, Номхон далай

Усны нөөцийн менежмент нь сүүлийн 10 жилийн хугацаанд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үндсэн үйлчилгээний хангамж, хүнсний үйлдвэрлэлийг сайжруулах, аж үйлдвэрийн хөгжил, экосистемд суурилсан үйлчилгээ зэргээрээ бүс нутгийн эдийн засаг, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулсан. Гэсэн хэдий ч Ази, Номхон далайн бүс нутаг нь ТХ-ийн 6-р зорилгод хүрэх болоогүй хэвээр байна.

Цаашлаад, усны хүртээмжийн тэгш бус байдлын асуудал шийдэгдээгүй хэвээр байна. Орон нутагт ус цуглуулах ажлыг хариуцдаг эмэгтэйчүүд эрх мэдлийн тэнцвэргүй байдал, нийгэм соёлын хүчин зүйлс зэрэг уламжлалт хэм хэмжээ, дадлын улмаас усны менежментэд оролцох оролцоо хязгаарлагдмал байсаар байна. Бүс нутгийн бусад сорилтуудад ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ дутмаг байдал, усны бохирдол, хил дамнасан хамтын ажиллагааны хангалтгүй байдал зэрэг орж байна.

Энэ бүс нутагт одоо байгаа түншлэл, сүлжээг бэхжүүлж, оролцогч талуудын оролцоог бүхий л түвшинд сайжруулахын тулд байгаа платформуудаа сайжруулж, холбогдох оролцогч талуудыг усны засаглалд хамруулах шаардлагатай байна. Үндэстэн дамнасан болон үндэсний түвшний төрийн байгууллагуудын оролцоотой засаглалын арга барил нь усны менежментийн үндсэн чиг хандлага, санхүүжилтийг дэмжиж, уснаас хамааралтай бусад салбарын ахиц дэвшлийг хурдасгах болно.

Арабын бүс нутаг

Энэ бүс нутгийн гадаргын усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлт, хил дамнасан усны нөөцөөс хамааралтай байдал, хөдөө аж ахуйн салбарын усны нөөцийн өндөр хэрэглээ зэрэг өсөн нэмэгдэж буй бэрхшээлүүд нь усны аюулгүй байдлыг хангахад ахиц дэвшил

гаргахын тулд хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулж, холбогдох санаачилгуудыг амжилттай хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Арабын бүс нутагт хэд хэдэн ийм зохицуулалтыг хамтын ажиллагаанд саад учруулж болзошгүй санхүүгийн болон улс төрийн саад бэрхшээлийг үл харгалзан эхлүүлсэн. Эдгээр нь усны менежментийг сайжруулахад хамтын хүчин чармайлт, харилцан итгэлцлийг бий болгох үйл явц болон мэдээлэл солилцоо чухал ач холбогдолтой болохыг харуулсан. Тиймээс хамтын ажиллагааг сайжруулж, ялангуяа санхүүжилтийг нэмэгдүүлэн инновацыг хөгжүүлэх болон мэдээлэл солилцоо замаар тус бүс нутагт тулгамдаад байгаа олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Арабын ихэнх орнууд ус хангамжийн хувьд хил дамнасан гол мөрөн ба/эсвэл уст давхаргаас ихээхэн хамааралтай байдаг. Хөрш зэргэлдээ орнуудын зарим улсын хооронд тодорхой зөрчилдөөнүүд байгаа хэдий ч хил дамнасан уст давхаргын асуудлаарх хамтын ажиллагааны хэд хэдэн жишээ энэ бүс нутагт байдаг. Хил дамнасан хамтын ажиллагааны эдгээр зохицуулалт нь зорилтот мэдээллийг солилцоо, мэдээлэл цуглуулах, шинжлэх ухааны судалгаа хийх зэрэг итгэлцлийг бэхжүүлэх үйл явцаар дамжуулан усны менежментийг сайжруулахад хувь нэмэр оруулахын сацуу хамтын ажиллагааны нэгэн бат бөх арга хэрэгсэл нь болоод байна.

Өөрчлөлтийг хурдасгах

Дараах хэсгүүдэд түншлэл, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой **ТХ-ийн 6-р зорилгын хэрэгжилтийг дэлхийн дахинд хурдасгах санаачилга (Global Acceleration Framework)-ын таван хурдасгагч хүчин зүйлсийг тус тус харуулав**. Ийм түншлэл, хамтын ажиллагаа нь хилийн зааг болон салбараар хязгаарлагдахгүйгээр ТХ-ийн 6-р зорилгыг хэрэгжүүлэхэд хүн бүрийн анхаарлыг хандуулахад тус дөхөм болдог.

Боловсрол ба чадавхыг бэхжүүлэх

Боловсрол, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа нь усны менежментийн илүү тогтвортой, шударга дадлага туршлагыг хөгжүүлэх, нэвтрүүлэх болон хэм хэмжээ болгох ажлыг хурдасгахад чухал ач холбогдолтой юм. Үүнд багш, оюутнууд, байгууллагууд болон бусад мэдээлэл түгээгч, хүлээн авагчид хоорондоо мэдлэг туршлага, ур чадвараа хуваалцах ажил багтдаг. Технологийн дэвшил нь хамтын ажиллагааны ийм хэлбэрүүдийн гол хөдөлгөгч хүч юм. КОВИД-19 цар тахал нь дижитал контентийг дэлхийн хэмжээнд хөгжүүлж, мэдээлэл, харилцаа холбооны технологийг сургах, суралцахууд хэрэглэдэг болоход томоохон түлхэц болж өгсөн. Дэлхийн олон орны усны менежментэд орон нутгийн мэдлэг, туршлага чухал үүрэг гүйцэтгэдэг. Орон нутгийн мэдлэг туршлага нь ихэвчлэн экосистемийн үйлчилгээ үзүүлдэг байгалийн үйл явцууд дээр үндэслэсэн байдаг тул уян хатан байдал, дасан зохицох чадварыг нэмэгдүүлдэг. Орон нутгийн мэдлэг, туршлагауудыг нэгтгэхэд эдгээрийг эзэмшигч нийгэмлэгүүд болон мэргэжлийн сүлжээдийг хамруулсан олон талт мэдлэг солилцооны хэлбэрүүд шаардлагатай юм.

Гэвч үүнийг бий болгоход олон саад бэрхшээл тулгардаг. Үүнд эмзэг бүлгийнхэн болон олон нийтийн мэдээлэл солилцооны хүртээмжийг нэмэгдүүлэх цахим платформ, системийг бий болгох зэрэг техникийн шинж чанартай сорилтууд багтдаг. Гэсэн хэдий ч усны боловсрол, чадавхыг илүү үр дүнтэй, тогтвортой, тэгш байдлаар хөгжүүлэхэд чиглэгдсэн түншлэл нь орон нутгийн мэдлэг, туршлага, иргэний шинжлэх ухаан, нээлттэй инновац, насан туршийн боловсрол гэх мэт чиг хандлагуудыг илүү өргөн хүрээнд нэвтрүүлэхэд үр ашигтай юм.

Дэлхийн олон орны усны менежментэд орон нутгийн мэдлэг, туршлага чухал үүрэг гүйцэтгэдэг.

Нөөцийн хяналт, менежментийн чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд нь устай холбоотой эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг цогцоор нь бий болгох чадваргүй байдаг.

Иргэний шинжлэх ухааны олон төслүүд нь эрдэмтэд, усны мэргэжилтнүүд болон олон нийтийг нэгтгэдэг салбар хоорондын түншлэл байдаг. Эдгээр төслүүд нь ихэвчлэн боловсролын өргөн цар хүрээг хамардаг бөгөөд усны бохирдол, нөөцийн тэгш хуваарилалт зэрэг орон нутгийн асуудлуудыг сурталчлан таниулах, ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд илүү ихээр ашиглагдаж байна.

Өгөгдөл, мэдээлэл

Өгөгдөл, мэдээлэл нь устай холбоотой шийдвэрүүдийг гаргахад зайлшгүй шаардлагатай байдаг. Устай холбоотой өгөгдлийн боломжит хамрах хүрээ нь өргөн боловч орон нутгийн түвшнээр тогтохгүй үндэсний түвшинд ч мөн адил мэдээллийн хомсдол байсаар байна. Мөн түүнчлэн өгөгдөл мэдээллийн солилцоо хангалтгүй, нарийвчлан боловсруулсан мэдээлэл байхгүй зэрэг бэрхшээлүүд байсаар байна. Устай холбоотой өгөгдлийг ихэвчлэн төрөл бүрийн хэрэглэгчид (эсвэл “салбарууд”) бүрдүүлдэг тул нэр томьёо болон бусад хүчин зүйлсийн ялгаатай байдлаас шалтгаалан олон хэрэглэгчид эдгээр мэдээллийг харилцан солилцох боломжгүй байдаг. Хэдийгээр өгөгдлийг төвийг сахисан гэж үзэж болох ч тус өгөгдлийг ашиглан хийсэн дүн шинжилгээний үр дүн нь өөр дүр зургийг илтгэж байж болох юм. Тиймээс түншлэл нь өгөгдлийг бүтээлчээр үүсгэж, бодит мэдээлэл болгон боловсруулахад тус дөхөм болдог.

Тэргүүлэх зорилтыг тодорхойлох, төлөвлөх, мэдээлэл цуглуулах, мэдээллийн засаглалын механизмыг хамтран боловсруулахад түншүүдийг илүү өргөн хүрээтэй оролцуулах үйл явц нь хамтын өмчлөлийг дэмждэг. Түншлэлийг амжилттай болгодог гол хүчин зүйлс нь цаг хугацаа, ил тод байдал болон харилцан хүндэтгэл юм.

Зорилтуудын талаар нэгдсэн ойлголтод хүрэхийн тулд эхлээд нийтлэг ашиг сонирхол бүхий талбаруудыг судалж, хүлээгдэж буй үр дүнгийн талаар хэлэлцэн, итгэлцлийг бий болгох шаардлагатай. Зөвлөгөөн, харилцаа холбоо, харилцан зөвшилцөл нь эдгээр үйл явцын туршид чухал ач холбогдолтой юм.

Нээлттэй хандалт бүхий дэлхийн мэдээллийн сангуудыг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд ашиглаж болох боловч эдгээр сангийн өгөгдөл мэдээллийг илүү оновчтой зүйлд ашиглахад шаардагдах орон зайн нарийвчлал эсвэл нарийвчилсан мэдээлэл нь хангалтгүй байдаг. Хөдөө аж ахуй, байгаль орчны үйлдвэрлэл зэрэг нөөцийн хяналт, менежментийн чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд нь устай холбоотой эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг цогцоор нь бий болгох чадваргүй байдаг. Эдгээр байгууллагууд нь байгаа мэдээллээ хоорондоо хуваалцах боломжгүй (эсвэл хуваалцахаас татгалзсан) тохиолдолд бэрхшээлүүд үүсдэг.

Хил дамнасан усны нөөцийн хамтарсан хяналт нь системийн талаарх нийтлэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, өгөгдлийг цаг тухайд нь хуваалцаж, ашиглах платформыг бий болгодог. Гол мөрний сав газрын байгууллагууд, үндэсний төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, хөгжлийн байгууллагууд зэрэг хил дамнасан улс орнуудын оролцогч талууд нь энэхүү платформуур дамжуулан нэгтгэж, хуваалцах боломжтой мэдээллүүдийг эзэмшдэг. Төрөл бүрийн мэдээллийн санг үндэсний хэмжээнд болон олон улсын түвшинд нэгтгэхэд төрийн байгууллагууд болон компаниуд, газар эзэмшигчид зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай.

Инновац

Түншлэл нь мэдлэг дамжуулалт, бизнес эрхлэлт, хэрэглээний судалгаа зэргээр дамжуулан шинэлэг технологийн хөгжил болон ашиглалтыг хурдасгах боломжийг бий болгодог.

Их дээд сургуулиудын хоорондын Өмнөд-Хойд, Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, өргөжүүлэх замаар шинэ технологи, шинэлэг үр чадварыг дамжуулахад түлхэц өгөх боломжтой. Бизнес инкубаторууд болон хурдасгуурууд нь их дээд сургуулиуд, шинээр гарч ирж буй бизнес эрхлэгчид болон хамтарсан хөрөнгө оруулагчдын хоорондын түншлэлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс дунд болон бага орлоготой орнуудад ийм инкубаторуудыг хөгжүүлж, өргөжүүлэх хэрэгтэй юм. Хойд болон Өмнөдийн түншүүдтэй хамтран шинэ мэдлэгийг бий болгож, шинэлэг зүйлсийг санаачилдаг нийгмийн бүлгүүд нь техникийн хувьд боломжтой, эдийн засгийн хувьд ашигтай, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдлүүдийг боловсруулахад ихээхэн хувь нэмэр оруулж чадах юм.

Ус боловсруулах, түгээх, цэвэршүүлэх шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг хурдасгахын тулд ус, ариун цэврийн байгууламжийн салбарт шинэ түншлэлүүдийг бий болгох шаардлагатай байна. Үүнд их дээд сургууль, бизнес эрхлэгчид зэрэг аж үйлдвэр болон технологийн ханган нийлүүлэгчдийн түншлэлээр дамжуулан хүрч болно. Мэдээлэл харилцаа холбооны технологи (МХХТ) зэрэг шинэ технологи, инновацыг нэвтрүүлсний ашиг тусыг цахилгаан, ялангуяа интернет, гар утасны үйлчилгээнд холбогдоогүй хүмүүс хүртэж чадахгүй юм. Тиймээс шинэ технологи нэвтрүүлэхдээ мэдлэгийн болон нийгэм-эдийн засгийн хуваагдлыг нэмэгдүүлэх зэрэг хүсээгүй сөрөг үр дагаварт хүргэхгүй байхад анхаарал хандуулах шаардлагатай юм.

Санхүүжилт

2030 он гэхэд хүн бүрийг ундны усаар тэгш хүртээмжтэй байдлаар хангахын тулд одоогийн хөрөнгө оруулалтын хэмжээг гурав дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээтэй холбоотой зарим санхүүжилт нь нэн ядуу хүмүүсийн хэрэгцээг хангах асуудлыг шийдвэрлэх бус харин бүр эсрэгээрээ зорилтот бүлэгт хүрэхгүй байгааг зарим нотлох баримтууд харуулж байна.

Оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах нь устай холбоотой хөрөнгө оруулалтыг төрөл бүрийн эх үүсвэрээс санхүүжүүлэх нэмэлт урсгалыг бий болгоход түлхэц болох юм. Хамтын ажиллагааны механизм нь ашиг хүртэгчдийг нэгтгэх гол түлхүүр нь болох бөгөөд үүгээр дамжуулан холбогдох төслүүдийн хамтарсан санхүүжилтийг бүрдүүлэх боломжтой. Устай холбоотой асуудалд чиглэсэн сангууд нь төрөл бүрийн оролцогч талуудын санхүүжилтийг нэгтгэдэг олон талт платформуудын нэг жишээ юм.

Төрөл бүрийн санхүүжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа нь хамтын санхүүжилтийн тогтолцоог дэмжин хөгжүүлэх хөшүүрэг нь болж чадна. Хөрөнгө оруулалтын эрсдэлийг олон (эрсдэлтэй холбоотой дур сонирхол, хэрэгцээ шаардлага нь ялгаатай) санхүүжүүлэгчдийн дунд хуваах замаар төрийн болон хөгжлийн санхүүжилтийг төслийн эрсдэл-өгөөжийн төлөв байдлыг сайжруулж, нэмэлт хөрөнгө оруулалтыг дайчлах зорилгоор стратегийн хувьд ашиглаж болох бөгөөд үүнийг “холимог санхүү”-ийн зохицуулалт гэж нэрлэдэг.

Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хэрэглэгч болон нийлүүлэгчдийн хамтын ажиллагааг сайжруулах нь (i) хэрэглэгч болон нийлүүлэгч талуудын төсөөлөл, шинж чанар, хэрэгцээ шаардлага; (ii) зуучлагч байгууллагууд, тэдгээрийн төрөл бүрийн чиг үүрэг; (iii) устай холбоотой эрсдэл, үр ашгийг санхүүгийн салбарт хамааралтай, ойлгомжтой нэр томъёогоор илэрхийлэх талаар мэдлэг ойлголтыг сайжруулах зэрэг ач холбогдолтой.

Оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах нь устай холбоотой хөрөнгө оруулалтыг төрөл бүрийн эх үүсвэрээс санхүүжүүлэх нэмэлт урсгалыг бий болгоход түлхэц болох юм.

Өрхийн түвшний ус хангамж, ариун цэврийн байгууламжид зориулсан хөрөнгө оруулалт нь орлого багатай хэрэглэгч, өрхөд зориулсан бичил зээл гэх мэт санхүүгийн тодорхой бүтээгдэхүүнийг шаарддаг тул холбогдох төслүүдийг дэмжин, бүх талуудад эерэг нөлөө үзүүлэх хөрөнгө оруулагчид (impact investors)-ын хөрөнгө оруулах сонирхлыг өдөөх боломжтой.

Засаглал

“Нийгэм бүтнээрээ оролцох” (whole-of-society approach) арга барил нь бодлогын зорилго, түүнд хүрэх арга хэрэгслийн талаар нийгэм даяар нэгдсэн тохиролцоонд хүрэхэд албан болон албан бус институцийг оролцуулах зорилготой.

Итгэл, найдвар нь нийгмийн эв нэгдэл, аюулгүй байдлын үндэс суурь нь юм. Итгэл нь эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг хангахад (“дугуйг тослоход”) шаардлагатай нэг чухал хүчин зүйл (“тосолгоо”) болдог бол харин найдвар нь нийгмийн бүлгүүдийг хооронд нь холбож өгдөг. Авлигатай тэмцэх нь усны салбарт ихээхэн хэмжээний зардлыг хэмнэж, үйл ажиллагааг цуцлах, саатуулах тохиолдлын тоог бууруулдаг болох нь судалгаагаар тогтоогдсон.

Талуудын үр дүнтэй оролцоог хангасан үйл ажиллагаа нь цаг хугацаа шаарддаг боловч итгэл, найдварыг бий болгодог. Бодлого, төслийн үйл явц нь төрөл бүрийн бүлгүүдийн тулгамдсан асуудлууд, боломжит хувь нэмэртэй уялдаатай байх шаардлагатай. Холбогдох салбарууд болон оролцогч талуудын анхаарлыг татсан асуудлуудыг стратегийн хувьд нэгдмэл байдалд оруулахын тулд ус ашиглалтын үр ашиг, салбар дундын нөөцийг хамгаалахад нөлөөлөх хэм хэмжээ, стандарт, хуваарилалтын аргуудыг боловсруулах шаардлагатай юм.

Улсынхаа нэрийн өмнөөс ажиллаж буй эрх бүхий байгууллагууд нь ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээгээр хангахад хувийн хэвшлийн операторуудыг оролцуулах эсэх, оролцуулбал хэрхэн оролцуулах талаар шийдвэрийг гаргадаг. Эдгээр эрх бүхий байгууллагууд нь баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан байх хүний эрхийг үе шаттайгаар хэрэгжүүлэх эрх үүргээ хадгалан үлддэг. Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) нь бүх оролцогч талуудад ашигтай хамтын ажиллагаан дээр тулгуурласан байх шаардлагатай бөгөөд нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үйлчилгээг ханган нийлүүлж буй байгууллагадаа ч мөн зохих өгөөжийг өгдөг байх хэрэгтэй юм. Хувийн хэвшлийн болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь тодорхой, урьдчилан таамаглах боломжтой, тогтвортой хууль эрх зүйн орчинтой улс орнуудад илүү үр дүнтэй байдаг. Хууль эрх зүйн ийм орчин нь урт хугацааны хөрөнгө оруулалтыг итгэлтэйгээр хийж, зохих өгөөжийг хүртэх боломжийг бүрдүүлдэг.

Дүгнэлт

Усны тогтвортой менежментээр дамжуулан ус, хүнс, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, хүн бүрийг ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, хүний эрүүл мэнд, амьжиргааг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн эрс тэс үзэгдлүүдийн нөлөөллийг бууруулах, экосистем, түүний үзүүлж буй үйлчилгээг тогтвортой байлгаж, нөхөн сэргээж байх зэрэг нь авах шаардлагатай цогц арга хэмжээнүүдийн салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд юм.

Зөвхөн түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд л талууд нэгдэх боломжтой юм.

Мөн бүх талууд өөр өөрийн үүрэг хариуцлагатай.

Дэлхийн усны үнэлгээний хөтөлбөрийн газрын захирал Микела Милетто, Ерөнхий редактор Ричард Коннор нар хариуцан бэлтгэв.

Энэхүү хэвлэлийг НҮБ-ын Ус хөтөлбөрийн нэрийн өмнөөс Дэлхийн усны үнэлгээний хөтөлбөрийн газраас боловсруулан гаргав.

Хавтасны зураг: Давиде Бонаци

Орчуулсан: ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Марко Тонсини



© ЮНЕСКО 2023

ЮНЕСКО-ийн зүгээс энэхүү хэвлэлд ашигласан нэр томъёо, материалаар дамжуулан аливаа улс, нутаг дэвсгэр, хот эсхүл бүс, тэдгээрийн удирдлагын эрх зүйн статус, хил хязгаар, заагтай холбоотой байр суурийг илэрхийлээгүй болно. Энэхүү хэвлэлд ашигласан баримт материал, илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчдын үзэл санаа, байр суурь бөгөөд ЮНЕСКО-ийн байр суурийг илэрхийлээгүй тул тус байгууллага аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Зохиогчийн эрх болон лицензийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.unesco.org/water/wwap цахим хуудсан дахь Дэлхийн усны хөгжлийн тайлангийн дэлгэрэнгүй хувилбараас авна уу.

ЮНЕСКО-ийн Дэлхийн усны үнэлгээний хөтөлбөр
Дэлхийн усны үнэлгээний хөтөлбөрийн газар
ЮНЕСКО-ийн Усны шинжлэх ухааны салбар
06134 Коломбелла, Перуджа, Итали Улс
Имэйл: wwap@unesco.org
www.unesco.org/water/wwap



unesco

World Water
Assessment Programme

Энэхүү хураангуйг боловсруулан гаргахад санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Итали улсын Умбриа мужийн Засгийн газарт талархал илэрхийлье.

Монгол хэлнээ хөрвүүлсэн хувилбарыг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс болон ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр орчуулан хэвлүүлэв.

